



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 718

Улаанбаатар хот

Автомашины тоо, төрөл тогтоох тухай

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн яамны салбарын үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан Сангийн яамны үндсэн үйл ажиллагаа дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашины ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2. Албан хэрэгцээнээс илүү гарсан, үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлага хангахгүй байгаа автомашиныг данснаас хасах, хэрэгцээт байгууллагад шилжүүлэх саналаа ирүүлэх;

2.3. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007179

35-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн
713 дугаар тогтоолын хавсралт



САНГИЙН ЯАМНЫ ДОТООД АЛБАН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД
АШИГЛАГДАХ АВТОМАШИНЫ АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ

№	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
1	Үйлчилгээний автомашин	Хөдөө ажлын автомашин /туулах чадвар сайтай/	1
2		Хот доторх ажлын суудлын автомашин	1
3		Хөдөө, хот доторх ажлын жижиг оврын автобус /Микро автобус/	1
Нийт автомашин			3